



ДОРНОГОВЬ АЙМАГ
“ЧАНДМАНЬ-ИЛЧ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 7/2024

Сайншанд сум

Журам батлах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухайн хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1, 27.3.3 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалт, компанийн хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, компанийн Захирлын зөвлөлийн 2024 оны 37 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцооны ISO45001:2018 стандартын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан компанид мөрдөх "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгохыг нэгжийн удирдлага, нийт ажилтнуудад үүрэг болгосугай.


3.Журмын хэрэгжилтийг хангуулж, үр дүнг тооцож ажиллахыг Хяналтын хэлтэст, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженерт тус тус даалгасугай.

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ө.ДАВААЖАВ

44124075



НЭГ. ЖУРМЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

1.1. Энэхүү журмаар Чандмань-Илч ХХК-ийн удирдах болон нийт гүйцэтгэх ажилтнууд ажил албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, ажилтны эрүүл, зохистой орчныг бүрдүүлэх, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журмыг тус компанийн ажилтнууд болон ажил гүйцэтгэх гэрээгээр компанийн үйлдвэрлэлийн орчинд ажиллаж буй гэрээт байгууллагын ажилтан, албан хаагчид дагаж мөрдөх үүрэгтэй.

1.3. Гэрээгээр ажил гүйцэтгэж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь тус бүрийн үйл ажиллагаанд тавигдах холбогдох хууль, тогтоомж дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллах ба өөрсдийн ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хариуцан, үүнээс үүдэх аливаа үр дагаврыг хариуцна. Гэрээт байгууллагын ажилтан албан хаагчид нь компанийн эрх бүхий ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх тавьсан зүй ёсны шаардлагыг биелүүлэх, дагаж мөрдөх үүрэгтэй.

1.4. Энэхүү журмын хэрэгжилтэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер нар хяналт тавина.

1.5. Энэхүү журмыг компанийн ажилтан, гэрээт байгууллагын ажилтан болон компанийн үйлдвэрлэлийн орчинд зөвшөөрлийн дагуу нэвтэрсэн бусад этгээд зөрчсөн бол Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, компанийн дотоод журам, байгуулсан гэрээг үндэслэн хариуцлага ногдуулна.

1.6. Шаардлагатай гэж үзвэл үйлдвэрлэлийн технологийн ажлын шат дамжлага тус бүрд дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх журмыг нэгжийн удирдлага боловсруулж ХАБЭА-н инженерээр хянуулсны дараа захирлаар батлуулж мөрдөнө.

1.7. Ажилтан болон бусад этгээд ажиллах нөхцөл болон ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах болон үүнтэй холбогдох санал хүсэлтээ ХАБЭА-н инженерт гаргаж болно. ХАБЭА-н инженер хүсэлтийг хүлээн авч шаардлагатай гэж үзвэл санал боловсруулан Хяналтын инженерт танилцуулж шийдвэрлүүлнэ.

1.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй гэдэг нь хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ, эмчлэх сувилах, нөхөн сэргээх, эрсдлээс хамгаалах үйл ажиллагааг хэлнэ.

1.9. Үйлдвэрлэлийн (Дулааны станц, усны эх үүсвэрийн байгууламж, ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж, үйлдвэрийн агуулах, авто граж гэх мэт) орчинд гадны хүнийг зөвшөөрөлгүйгээр нэвтрүүлэхгүй.

ХОЁР. НИЙТЛЭГ ШААРДЛАГА:

2.1. Ажилтан бүр ажил эхлэхийн өмнө тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг бүрэн гүйцэд зохих ёсоор өмссөн, ажиллах чадвартай, ажлын байрны аюулгүй байдлыг хянаж, тоног төхөөрөмжүүд, багаж хэрэгсэл, машин механизм болон ажлын бусад хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг сайтар шалгана. Эрсдэл үүсч болзошгүй болон шаардлага хангахгүй нөхцөл үүссэн бол нэгжийн удирдлагад тухай бүр мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсний үндсэн дээр ажлыг эхлүүлнэ.

2.2. Ажилтнууд үйлдвэрлэлийн (ус, дулаан хангамж үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, бохир ус татан зайлуулах болон цэвэрлэх) ажлын үе шат бүрт мөрдөгдөх аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллана. Ажилтан өдөр бүр ажил эхлүүлэхийн өмнө цахилгааны, галын зэрэг тоног төхөөрөмж, машин механизмын гэх мэт холбогдох бусад аюулгүй байдлын ерөнхий хяналтыг хийнэ.

2.3. Ажлын байранд болон ажлын цагаар согтууруулах ундаа, мансууруулах бодис ба сэтгэцэд нөлөөлөх эм хэрэглэсэн, мөн эрүүл мэндийн байдал хэвийн бус, өөрийгөө удирдан жолоодох чадваргүй этгээдийг ажилд гаргах, үйлдвэрлэлийн орчин ба ажлын байр, талбай руу нэвтрүүлэхийг хориглоно. Ажилтан ажиллахаар ирэхдээ ажил амралтын цагийг зөв зохицуулсан ажил үүргээ гүйцэтгэх чадвартай байх нөхцөлийг бүрэн хангасан байна. Эрүүл мэндийн шалтгааны улмаас ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй бол удирдлагад мэдэгдэн, тусламж үйлчилгээ авна.

2.4. Ажилтан бүр эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх чадварыг эзэмшсэн байна. Ажлын байрны зөвшөөрөгдсөн байрлалд эмнэлэгийн анхны тусламжийн хайрцаг байршуулна. Осолд өртсөн ажилтанд анхан шатны тусламжийг үзүүлэн дараагийн шатны эмнэлэгт хүргэх боломжоор бүрэн хангасан байна.

2.5. Ажилд шинээр орж байгаа ажилтан бүр урьдчилсан зааварчилга авч, үйлдвэрлэлд бие даан ажиллахын өмнө компанийн захиргаанаас тогтоож өгсөн хугацааны турш туршлагатай ажилтныг дагалдан мэргэшлийн дадлага хийнэ.

2.6. Ажилтан аюулгүй ажиллагааны зааварчилга авч гарын үсэг зурсны дараа ажилд гарна.

2.7. Аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж шалгалт өгөөгүй болон мэргэшлийн дадлага сургууль хийгээгүй шинээр ажилд орж байгаа ажилтныг үйлдвэрлэлд бие даан ажиллахыг хориглоно.

2.8. Ажилтан бүр ажил олгогчийн баталсан жагсаалтын дагуу ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдах ба тэдгээрийг бүрэн гүйцэт, зохих ёсоор зориулалтын дагуу өмсөнө.

2.9. Ажилтан бүр ажил олгогчийн баталсан жагсаалтын дагуу хор саармагжуулах бүтээгдэхүүн ба хавар, намрын витаминжуулалтаар бүрэн хангагдах ба тэдгээрийг зөвхөн өөрөө хэрэглэнэ.

2.10. Ажлын байр өөрчлөгдөж нэг хэсгээс нөгөөд шилжин ажиллахдаа тухайн ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байна.

2.11. Ажилтан нь албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргээ гүйцэтгэх үед машин техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, аюулгүй ажиллагааны зааврыг чанд сахиж ажиллана.

2.12. Галын болон цахилгааны аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.

2.13. Шатахуун хадгалах цэг, дизель генератор, автограж, цэвэрлэх байгууламж, нүүрс хадгалах талбай, түлш дамжуулах байгууламжийн ойр орчимд гагнуур хийж, ил гал гаргах, тамхи татах, мөн оч үсэргэдэг тоног төхөөрөмж ажиллуулахыг хатуу хориглоно.

2.14. Цахилгааны утсыг залгаж, салгахыг дур мэдэн үйлдэх буюу үйлдүүлэхгүй байх ба холбогдох инженерээс зөвшөөрөл авч мэргэжлийн ажилтнаар гүйцэтгүүлнэ.

2.15. Ажилтан болон үйлдвэрлэлийн бүсэд нэвтэрсэн бүх этгээд өөрийгөө болон бусдыг аюул эрсдэлд учруулахгүй байх бүх нөхцөлийг ханган ажиллах үүрэгтэй. Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй байдлын дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авна.

2.16. Албан үүргээ гүйцэтгэх үедээ ажлын байраа эзэнгүй хаяж явахыг хориглоно. Зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд ахлах ажилтанд мэдэгдэж зөвшөөрөл авсны үндсэн дээр ажлын байрыг орхино. Ажлын цаг дуусмагц ажлыг зогсоож ойр орчмын аюулгүй байдлыг шалгаж ажлын байр, талбайн эмх цэгцийг ханган цэвэрлэж, тоног төхөөрөмжийг зааврын дагуу унтраах буюу салгана.

2.17. Ажиллах явцад тоног төхөөрөмжид эвдрэл, доголдол үүссэн тохиолдолд нэгжийн удирдлагад мэдэгдэж засварласны дараа ажиллуулж болно гэсэн зөвшөөрлийн үндсэн дээр ажлыг үргэжлүүлнэ.

2.18. Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, засвар үйлчилгээ, тохируулга хийгдэж байгаа тохиолдолд аюулгүйн анхааруулга, тэмдэг байрлуулах ба энэ үүргийг засвар хийж буй ажилтан хариуцна.

2.19. Анхааруулах тэмдэг байрлуулсан орчимд хүрэх, нэвтрэх, тэмдэг тэмдэглэгээг дур мэдэн өөрчлөх ба тоног төхөөрөмжийг ажиллуулахыг хориглоно.

ГУРАВ. АЖИЛТНЫ ҮҮРЭГ:

3.1. Ажилтан нь сайн амарсан, нойр гүйцэд авсан, ажил гүйцэтгэхэд бэлэн ирэх ёстой. (ядарсан, дутуу амарсан ажилтан ажлын идэвхи сул, өөрийгөө болон бусдыг хянах чадвар муу байдгаас ажлын байран дээр үүрэглэх эсвэл анхаарал түр сарних тохиолдолд аваар осол гаргах магадлалтай бөгөөд өөрийгөө төдийгүй бусдыг аюулд оруулж болзошгүй)

3.2. Ажилтан ажилдаа ирэх болон ажил тарсны дараа гэр руугаа буцахдаа батлагдсан замын маршрутын дагуу явах ёстой.

3.3. Ажилтан өөрийн биеийн байдалд өөрчлөлт (толгой өвдөх, нүд эрээлжлэх, халуурах, дотор эвгүйрхэж тавгүйдэх гэх мэт) мэдрэгдэх тохиолдолд нэгжийн удирдлагад яаралтай мэдэгдэх, улмаар эмчид хандан оношлуулах ёстой.

3.4. Ажилтан эрхэлдэг ажлынхаа мэдлэгийг байнга дээшлүүлж, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах талаар зохион байгуулагдах сургалтад сууж шалгалт өгч дүгнүүлнэ.

3.5. Ажилтан бүр ажил эхлүүлэхийн өмнө буюу ажилд шинээр орж буй ажилтан, өөр ажлын байранд шилжин ажиллаж буй ажилтан, мөн нэг сараас илүү хугацаагаар ажлаас хөндийрч яваад эргэж ажилдаа орсон ажилтнууд тухай бүр хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгыг авсан байна.

3.6. Үйлдвэрлэлийн орчинд компанийн дотоод журам, үйл ажиллагаа явагдаж буй ажлын байр, зам талбайд аюулгүй ажиллагааны дүрэм, заавар хэрхэн хэрэгжиж байгаа талаар өөрийнхөө болон хамт олныхоо үйл ажиллагаанд хяналт тавьж зөрчил дутагдлыг арилгах талаар өөрөөс шалтгаалах арга хэмжээг авах ба удирдах албан тушаалтанд мэдээлэх;

3.7. Машин техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа алдагдах, ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, журам зөрчигдсөн зөрчил, илрэл гарсан тухай бүрд удирдах албан тушаалтанд яаралтай мэдэгдэх;

3.8. Ажилтан бүр эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх чадвартай байх.

3.9. Ажилтан нь өөрийн ажлын байрыг эзэнгүй орхихгүй байх, машин механизм, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хийж буй ажлын явцын талаарх мэдээллийг мэдсэн байх, ажлын байранд гадны хүн оруулахгүй байх үүрэгтэй.

3.10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах талаар удирдлагын өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх.

3.11. Ажил үүргээ гүйцэтгэх явцдаа бусдын анхаарлыг сарниулах, чанга дуу чимээ гаргах, дэмий сэлгүүцэх, бусдад саад болох аливаа үйлдэл хийхгүй байх үүрэгтэй.

3.12. Заагдсан цэг дээр бус ажлын байр, талбай, үйлдвэрлэлийн орчин, автомашины бүхээг дотор мөн үйлдвэрлэлийн бусад зөвшөөрөгдөөгүй талбайд тамхи татах ба ил гал гаргахыг хатуу хориглоно.

3.13. Ажил үүргээ гүйцэтгэж дуусаад эмх цэгцийг сахиж хэрэглэсэн багаж, материалаа хурааж, хог хаягдлыг цэвэрлэж хэвших;

3.14. Нийтийн их цэвэрлэгээнд тогтоосон хугацаанд оролцох;

3.15. Үйлдвэрлэлийн бүсээс гарахдаа нэгжийн удирдлагад мэдэгдэж, зөвшөөрөл авч, цагаа бүртгүүлнэ.

3.16. Ажлын байрны ариун цэвэр, эрүүл ахуйг чанд сахиж, хурц хордлогоос үргэлж сэргийлнэ.

3.17. Ахуйн хог хаягдлыг тусдаа түр хадгалах, хаях цэгийг тэмдэгжүүлсэн байх ба зориулалтын бус газар хог, хаягдал хаяхыг хориглоно.

3.18. Заагдсан цэгээс бусад газар ил задгай бие засаж, угаадас, хог асгахыг хориглоно.

ДӨРӨВ. АЖИЛ ОЛГОГЧИЙН ҮҮРЭГ:

4.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмын хэрэгжилтийг дэмжиж ажиллахын тулд аливаа хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

4.2. Ажилтныг төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон хугацаат үзлэгт хамруулна.

4.3. Ажилтны эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг жил бүр төлөвлөж хэрэгжүүлэх ба эмчлэх сувилах, нөхөн сэргээх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагад хандан хийлгэнэ.

4.4. Тухайн жилд олон дахин бие өвдсөн, эмнэлэгийн акт авсан, мөн эрүүл мэндийн хувьд халдварт өвчин, хавдар зэрэг хүнд өвчин илэрсэн ажилтныг холбогдох чиглэлийн эмнэлэгт зуучилж эмчилж сувилуулна.

4.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөрийг батлуулан хуваарийн дагуу сургалтыг явуулах ба тусгай болон өндөр эрсдэлтэй ажлын байранд ажиллах ажилтнуудад мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө, сургалт авч болно.

4.6. Хэлтэс, хэсэг, салбарын инженер техникийн ажилтнууд өөрсдийн нийт ажилтанд сард нэг удаа аюулгүй ажиллагааны давтан зааварчилга өгнө.

4.7. Үйлдвэрлэлд дэвшилтэт техник технологи, хөдөлмөрийн шинэ арга барил нэвтрүүлэх, аюулгүй ажиллагааны дүрэм заавар өөрчлөгдөх, түүнчлэн цахилгаан эрчим хүч, ус хангамж ариутгах татуургын ба дулаан хангамжийн сүлжээ, машин тоног төхөөрөмжийн бүтэц, эд анги, ажиллах зарчим өөрчлөгдөх тухай бүрд компанийн захиргаанаас энэ талаар холбогдох бүх ажилтанд аюулгүй ажиллагааны ээлжит бус зааварчилга өгсөн байна.

4.8. Албан тасалгаа, ажлын байр, талбай, үйлдвэрлэлийн байрны орц, гарцын хонгил, аюултай хэсэг, аюул осол гарч болзошгүй газруудад анхааруулах тэмдэг, зурагт хуудас болон машин тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны заавар санамжийг ил тод харагдах газарт ойлгомжтой байрлуулна.

4.9. Аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг дагаж ажиллаагүй тохиолдолд компанийн зүгээс эд хөрөнгөнд учрах гарз хохирол болон ажилтанд учрах гэмтэл зэргээс сэргийлэх зорилгоор шууд засч залруулах арга хэмжээ авна.

ТАВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ:

5.1. Ажилтан нь зөвхөн өөрсдийн албан тушаалын тодорхойлолтод заагдсан буюу тухайн ажил хариуцсан инженерийн даалгасан ажлыг гүйцэтгэнэ. Нэгжийн удирдлага буюу инженер техникийн ажилтны зөвшөөрөлгүйгээр ажил гүйцэтгэхийг хатуу хориглоно. Шаардлагатай тохиолдолд ажилтныг мэргэжлийн туршлага шаардахгүй өөр ажил гүйцэтгүүлэхдээ холбогдох инженер техникийн ажилтнаас зөвшөөрөл авна.

5.2. Ажлын байр бүрийг ажил эхлэхийн өмнө эсвэл ажлын дундуур инженер буюу түүний даалгавраар ээлжийн мастер, ахлах ажилтан нар биечлэн шалгаж, аюулгүй ажиллагааны зөрчил илэрсэн үед нэгжийн удирдлагад мэдэгдэж зөрчлийг арилгах үйл ажиллагаа заавал хийнэ. Ажлын даалгаврыг ажлын явцад өөрчлөх шаардлага гарвал заавал анх шийдвэр өгсөн удирдах ажилтнаар дамжуулан гүйцэтгэнэ.

5.3. Ажилтан бүр ажил эхлэхийн өмнө ажлын байр, машин тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, ажилд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, тоноглолын гэмтэлтэй эсэхийг шалган хэрэв зөрчил илэрвэл нэгжийн удирдлагад мэдэгдсэний дараагаар шуурхай арилгана.

5.4. Ажилтан бүр галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал гарсан үед гал унтраах багаж хэрэгсэлтэй ажиллах, гал унтраах чадвар, мэдлэгийг эзэмшсэн байна. Ажлын байр, үйлдвэрлэлийн талбайд ил гал гаргахыг, амархан шатах материал, тэсэрч дэлбэрэх материалыг ажлын байранд байлгахыг хориглоно.

5.5. Жолооч зам, орчны байдлыг биеэр шалгаж, дуут дохио өгч хөдөлгөөнөө эхлэх ба байр эзлэх, хөдөлгөөний чиг өөрчлөхдөө бусдын хөдөлгөөнд саад учруулахгүй байх бүх нөхцөлийг хангана.

5.6. Хөдөлгөөн дунд явах зам дээр хүн таарах мөн ойр хавьд таарах үед дуут дохио өгч анхааруулна. Ухрах хөдөлгөөн эхлэхийн өмнө гурван удаа дуут

дохио өгөх ба ар тал нь жолоочид харагдах боломжгүй үед ухрах хөдөлгөөн хийхийг хориглоно.

5.7. Ажилтан нь машин механизм, цахилгаан тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээний гэмтэл, гал түймэр, хүчтэй салхи, шуурга зэрэг хүмүүс болон үйлдвэрлэлд осол хор хөнөөл учруулж болзошгүй аюул илэрвэл нэгжийн удирдлага, диспетчер инженер, ХАБЭА-н инженер нарт яаралтай мэдэгдэнэ.

5.8. Технологийн зориулалттай автомашин болон бүх төрлийн хүнд даацын машины бүхээгт шалгах эрх бүхий хүмүүс онцгой тохиолдолд захиргааны зөвшөөрлөөр хүн сууж явахыг зөвшөөрнө. Бусад үед аюулгүй ажиллагааны зааварт заагдсанаар барих эрх бүхий операторчноос өөр хүн давхар сууж явахыг хориглоно.

5.9. Ажил тарсны дараа мөн удаан хугацаагаар ажиллахгүй тохиолдолд эксковатор, дугуйт ачигч болон бусад машин техникийг ажлын байр, талбай, үйлдвэрлэлийн орчноос зайлуулан аюулгүй (зориулалтын зогсоол, автограж гэх мэт) газарт байрлуулж тэдгээрийн ажлын хэсгийг (утгуур, хусуур, шанага) газарт буулган хаалга үүдийг түгжиж цахилгаан тэжээлийн хүчдэлийг салгана.

5.10. Үзэгдэх орчин хязгаарлагдсан тоостой нөхцөлд хөдөлгөөнийг зогсоох, хальтиргаа гулгаатай (бороотой, цастай) замд тухайлсан зааварчилга авч анхаарал болгоомжтой хөдөлгөөнд оролцож ажлаа гүйцэтгэнэ.

5.11. Машин механизм, (насос, сэнс, хөдөлгүүр) тоног төхөөрөмжийг эргэх буюу хөдөлгөөнтэй хэсгүүдийн хаалт, хамгаалалт байхгүй үед ажиллуулахыг хориглоно. Хий, шингэн, дулаан болон цахилгаан эрчим хүчний тэжээлийг салгаж, эд ангийн хөдөлгөөн бүрэн зогссоны дараа машин механизмд үзлэг үйлчилгээ, цэвэрлэгээ засварын ажлыг хийнэ. Засварын ажлын явцад хий шингэний даралт, дулаан, цахилгааны эрчим хүч гэнэт залгагдах бүх боломжийг урьдчилан арилгасан байна.

5.12. 1,5 метрээс дээш өндөрт ажиллах үед хамгаалах бүс хэрэглэх бөгөөд зориулалтын ажлын талбай байхгүй үед хашлагатай зориулалтын тавцан шат ашиглана. Аливаа зүйлийг өргөх, буулгах, зөөх, хураах мөн өндөрт ажил гүйцэтгэх үед багаж хэрэгсэл бусад зүйлс доош унаж болзошгүй аюултай тул бүсийг тогтоох шаардлагатай гэж үзвэл хаалт, хашилт байрлуулна.

5.13. Ажилтан бүр осолд нэрвэгдэгсдэд үзүүлэх анхны тусламжийг үзүүлэх арга барил, мэдлэгийг бүрэн эзэмшсэн байна. Мөн компанийн болон өөрийн ажиллаж байгаа хэсэг, нэгж бүрийн “Гамшгийн үеийн ажлын төлөвлөгөө”-г судалж мэдсэн байх шаардлагатай.

5.14. Ажилтан нь өөрийн ажлын байр, талбай, үйлдвэрлэлийн орчинд элдэв бохир зүйл хаяж бохирдуулахгүй байх ажлын байрны соёлыг бүрэн хариуцаж ажиллана.

5.15. Ажлын байр, талбай, үйлдвэрлэлийн орчинд гадны зочид төлөөлөгчид болон эрх бүхий хүмүүс сургалтын танхимд зочилж “Зочны зааварчилга” авсны дараагаар нэвтэрнэ.

5.16. Ажлын байр, талбай, үйлдвэрлэлийн орчинд явах эрх бүхий хүнд машин механизм, автомашины хурдыг 20 км/цагаас дээш хэтрүүлэхийг хатуу хориглоно.

5.17. Компанийн ажилтнууд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх, үүргийг өндрөөр ухамсарлан дүрэм, журмыг чанд дагаж мөрдөнө.

5.18. Аливаа аюул осолд дөхсөн тохиолдлыг нэгжийн удирдлагад компанийн дотоод програм ашиглан аюулыг мэдээлэх хуудас бөглөх, утсаар эсвэл биеэр ирж мэдээлэх үүрэгтэй.

5.19. Аливаа химийн бодис, хольцтой ажилласны дараа гараа угаалгүйгээр эсвэл тус бодис, хольц ашигласан газраа хоол идэх, тамхи татах зэргийг хориглоно.

5.20. Аюулгүй ажиллагааны давтан (өдөр тутмын) зааварчилгыг орхигдуулсан буюу гарын үсэг зураагүй бол тэр өдрийг ажилласанд үл тооцно.

5.21. Ажилтан өөрийн хайхрамжгүй, хэнэггүй, үл ойшоосон байдлаас шалтгаалж нэг бүрийн хамгаалах хэрэгслийг дутуу буюу буруу ашиглах, аюулгүй ажиллагааны зааврыг зөрчих буюу зааварчилга авахгүй, дур мэдэн ажиллах гэх мэт хүчин зүйлээс хамааран гарсан аливаа хохирлыг ажилтан өөрөө хариуцна.

5.22. Энэхүү журмаар зохицуулагдаагүй харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

5.23. Үйлдвэрийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд аюул ослын үед ажиллах төлөвлөгөө болон Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс, түүний ажиллах журамд заасны дагуу ажиллана.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1. Компанийн болон гэрээгээр ажил гүйцэтгэгч байгууллагын ажилтнууд нь аюулгүй ажиллагааны сахилгын арга хэмжээний гол субъект нь байна.

6.2. Хамтран ажиллах гэрээгээр ажил гүйцэтгэгч байгууллагын ажилтнууд аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд захиалагч байгууллагын тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

6.3. Тухайн нэгжийн хүрээнд арга хэмжээ авагдаад тодорхой үр дүнд хүрээгүй тохиолдолд нэгжийн (инженер техникийн ажилтан, ахлах мэргэжилтэн гэх мэт) удирдлага нь хяналтын хэлтэст буюу ХАБЭА-н инженерт хандан дараа дараагийн арга хэмжээг авхуулна.

6.4. Аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд үр дүнгийн шагналт цалинг бууруулах, сахилгын хариуцлага тооцох төдийгүй ажлаас чөлөөлөх хүртэлх арга хэмжээ авч болно.

6.5. Ажилтан аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд ХАБЭА-н инженер үр дүнгийн шагналыг бууруулах арга хэмжээг шууд авч болно.

6.6. ХАБЭА-н инженерийн ажил үүргийнхээ дагуу тавьсан шаардлагыг удаа дараа эсэргүүцэх, чанаргүй гүйцэтгэх, эсвэл үл биелүүлэх тохиолдолд ХАБЭА-н инженер нь удирдлагад санал оруулан тухайн ажилтны цалинг 5-20% бууруулах, ажлаас чөлөөлөх хүртэл шийдвэр гаргуулан арга хэмжээ авхуулна.

6.7. Ажилтан аюулгүй ажиллагааны ноцтой (хүний эрүүл мэнд, амь насанд шууд аюул учруулах, тоног төхөөрөмжийн томоохон эвдрэл болон ажил түр зогсоход хүргэх хэмжээний) зөрчил гаргасан тохиолдолд сахилгын шийтгэл авах юмуу ажлаас шууд чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна. Энэ тохиолдолд

баримтжуулсан аман сануулга өгөхгүй ба 2 дахь удаагийн зөрчлийг өмнөх зөрчлөөс хойш нэг жилийн дотор үйлдсэн тохиолдолд ажлаас шууд чөлөөлөх арга хэмжээ авч болно.

6.8. Ажилтан хүний эрүүл мэнд, амь насанд шууд аюул учруулахгүй буюу бие махбодид ноцтой гэмтэл, тоног төхөөрөмжид ихээхэн хэмжээний хохирол учруулахгүй зөрчил анх удаа гаргасан тохиолдолд баримтжуулсан аман сануулга өгнө. 2 дахь удаагаа зөрчил гаргасан тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулна. Анх зөрчил гаргаснаас хойш нэг жилийн дотор 3 дахь удаагаа зөрчил гаргасан тохиолдолд шууд ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч болно.

6.9. ХАБЭА-н инженер нь ямар сахилгын арга хэмжээ авах талаар компанийн удирдлагад санал бодлоо хуваалцаж, зөвлөж болох ч өөрөө сахилгын арга хэмжээг шууд авахгүй.

ДОЛОО. УРАМШУУЛАЛ



























7.1. Ажилтан компанийн ажлын байран дахь аюулыг (аюулыг мэдээлэх хуудас, утсаар, өөрийн биеэр) холбогдох инженер техникийн ажилтанд мэдээлж бүртгүүлсэн тохиолдолд,

7.2. Ажлын байран дахь аюулын эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээг авсан эсвэл өөрөө арилгасан тохиолдолд,

7.3. Ажлын байран дахь аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөлөл ба аюулын эрсдэлийн түвшинг бууруулах, арилгах талаар оновчтой санал, шинэ бүтээл санаачилж холбогдох инженер техникийн ажилтанд уламжилсан буюу улмаар хэрэгжүүлсэн тохиолдолд,

7.4. Ажлын байран дахь аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөлөл ба аюулын эрсдэлийн түвшинг бууруулах, арилгах талаар оновчтой санал, шинэ бүтээл санаачилсан буюу арга хэмжээнд хамгийн их оролцоо гаргаж ажилласан тохиолдолд тус тус эрсдэлийн түвшинг эрэмбэлж үндсэн цалингийн 5-20 хүртэлх хувиар урамшууллыг тооцож олгоно.

7.5. Ажилтанд олгох урамшууллыг ХАБЭА-н зөвлөлийн хурлаар улиралд нэг удаа хэлэлцэж дүгнэж захирлын зөвлөлд танилцуулж шийдвэр гаргуулна.

Д/д	ТҮГЭЭЛТИЙН ЖАГСААЛТ			
	Хуулбарын дугаар	Хуулбар эзэмшигчийн албан тушаал, нэр	Гарын үсэг	Огноо
1		Ерөнхий инженер Ө.Даваажав		2024.11.15
2		Ерөнхий нягтлан бодогч Л.Наранхүү ✓		2024.11.15
3		Хүний нөөцийн менежер Б.Эрдэнэчимэг		2024.11.15
4		ШҮХ-ийн ахлах инженер Б.Бат		2024.11.19
5		ШҮХ-ийн ГТХАхлах инженер Л.Алтангэрэл		2024.11.15
6		СХАхлах инженер Н.Түвшинбаяр		2024.11.15
7		ЦА-ын хэсгийн ахлах инженер Б.Мөнхдөл		2024.11.15
8		Засварын инженер Б.Цэрэн		2024.11.19
9		Засварын инженер О.Болоргэрэл		2024.11.19
10		Засварын инженер Б.Амартүвшин		2024.11.15
11		Засварын мастер О.Мөнхбаатар		2024.11.19
12		Засварын мастер Э.Дэрийлаамятав		2024.11.19
13		Засварын мастер Э.Лойжханд		2024.11.19
14		ТҮХ-н дарга А.Содномпунцаг		2024.11.15
15		ХҮТ-ийн ахлах мэргэжилтэн Д.Одгэрэл		2024.11.15
16		ДХХ-ийн дарга Э.Амаржаргал		2024.11.15
17		Ашиглалтын инженер М.Төрболд		2024.11.19
18		Эх үүсвэр-2 инженер Ч.Түвшинбаяр		2024.11.19
19		УХАТХ-ийн дарга Э.Эрдэнэбаяр		2024.11.15
20		ЦБ-ийн технологийн инженер Г.Гантулга		2024.11.19
21		ТЗ салбарын дарга Х.Ганцацрал		2024.11.15
22		Даланжаргалан салбарын дарга		2024.11.15
23		Айраг салбарын дарга Ш.Шинэбилэг		2024.11.15
24		Алтанширээ салбарын дарга Ц.Оюунтулга		2024.11.15
25		Дэлгэрэх салбарын дарга Б.Батсүрэн		2024.11.15
26		Өргөн салбарын дарга С.Батболд		2024.11.15
27		Зүүнбаян салбарын дарга Э.Алтангадас		2024.11.15
28		Хөвсгөл салбарын дарга М.Сайнбуян		2024.11.15
29		Хатанбулаг салбарын дарга Б.Гантүвшин		2024.11.15
30		Иххэт салбарын дарга Г.Ганжигүүр		2024.11.15